



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАНИЛЦУУЛГА

2018 ОН



МАНДАЛГОВЬ ХОТ  
2019 ОН

## ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАНИЛЦУУЛГА

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМ

1. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
1.1. Хүн амын тоо, түүний өсөлт .....	4
1.2. Хүн амын нас, хүйсийн бүтэц.....	6
1.3. Хүн амын дундаж наслалт.....	8
1.4. Хүн амын нягтрал.....	10
2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН, ЦЭВЭР ӨСӨЛТ	
2.1. Төрөлт .....	10
2.2. Нас баралт.....	14
2.3. Гэрлэлт болон гэр бүл цуцлалт, үрчлэлт.....	16
3. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН.....	18
4. ӨРХ, ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ	
4.1. Өрх, өрхийн бүтэц, өсөлт.....	21
4.2. Хүн ам нийгмийн зарим үзүүлэлтүүд.....	22
4.3. Хавсралт хүснэгтүүд.....	29

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАЛ АЖ АХУЙ

1. Малтай өрх, малчдын тоо	
1.1. Малтай өрх, малчдын тоо.....	36
1.2. Мал өрхийн малын бүлэглэл.....	39
2. Мал тэжээвэр амьтдын тоо, бүтэц	
2.1. Малын тоо, бүтэц.....	41
2.2. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо.....	46
2.3. Төл бойжилт.....	47
2.4. Том малын зүй бус хорогдол.....	48
2.5. Малын хэрэглээний зарлага.....	49
2.6. Сүргийн бүтэц.....	49
3. Малжуулалт, худаг усны тайлан	
3.1. Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан.....	50
3.2. Шинээр гаргасан засварласан худаг.....	51
4. Газар тариалангийн үйлдвэрлэл.....	51

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. АЖИЛ ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЭЛ

1. Хөдөлмөрийн насны хүн ам.....	54
2. Эдийн засгийн идэвхтэй хүн ам /Ажиллах хүч/.....	54
3. Ажиллах хүчий үндсэн үзүүлэлтүүд.....	55
4. Ажиллагчид.....	56
5. Ажилгүй иргэд.....	59
6. Ажилгүйдлийн түвшин.....	62
7. Эдийн засгийн идэвхгүй хүн ам.....	64
8. Ажил хайгч иргэд болон ажлын байрны зуучлал.....	65
9. Албан бус секторт ажиллагчид.....	67
11. Хавсралт хүснэгтүүд.....	68

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА**

1. Аж үйлдвэр .....	70
1.1. Уул уурхай олборлох салбар.....	71
1.2. Боловсруулах аж үйлдвэр.....	73
1.3. Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж.....	76
2. Барилга.....	77
3. Тээвэр холбоо, дэд бүтэц.....	79
4. Бизнес регистрийн сан.....	80
5. Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	82


## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### **1. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

#### **1.1 Хүн амын тоо, түүний өсөлт**

2018 оны жилийн эцсийн байдлаар суурин хүн амын тоо 46820 болж өмнөх оны мөн үеэс 0.94 хувиар буюу 437 хүнээр өссөн байна. Энэ нь Монгол улсын суурин хүн амын 1.5 хувийг эзэлж байна. Суурин хүн амын тоонд өөр аймаг, нийслэл болон гадаадад 6-аас дээш сараар амьдарч байгаа иргэдийг оруулж тооцоогүй бөгөөд тухайн аймгаас гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа иргэд 273 байна.

### Аймгийн суурин хүн ам 2011-2018



Суурин хүн амын 49.7 хувийг эмэгтэйчүүд, 50.3 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна.

### Нийт хүн ам, эмэгтэй 2011-2018 он




Аймгийн хүн амын тооны өсөлтийн коэффициентийг 2008 оноос хойш харуулбал 2008-2014 онуудад аймгийн хүн ам 3.6-0.4 хувиар буурч, 2014-2018 онууд 0.9-1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### ХҮН АМЫН ЖИЛИЙН ӨСӨЛТИЙН КОЭФФИЦИЕНТ 2008-2018




Хүн амын тоог сумдаар авч үзвэл 10 суманд хүн амын тоо 0.2-6.8 хувиар өссөн бол, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайхан-Овоо, Адаацаг сумдад 0.3-2,6 хувиар буурч, 1 суманд өмнөх онтой ижил түвшинд байна. Аймгийн нийт хүн амын 34 хувь буюу 15762 нь Сайнцагаан суманд, 12.5 хувь буюу 5847 хүн Эрдэнэдалай суманд, 6.1 хувь буюу 2888 нь Адаацаг суманд амьдарч байна.

Хүн амын тоо сумдаар




Аймгийн төвд 12433 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 26.6 хувийг, сумын төвд 8802 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 18.8 хувийг эзэлж байгаа бол, хөдөөд нийт хүн амын 54.6 хувь буюу 25584 иргэн суурьшиж байна.

### Хүн ам байршлаар 2018



2018 оны жилийн эцсийн байдлаар Өндөршил суманд 1 баг шинээр нэмэгдсэнээр 67 багтай болж, тэдгээрийн 32 баг нь 400-600 хүн амтай, 17 баг нь 600-1000 хүн амтай, 12 баг нь 200-400 хүн амтай, байгаа бол 6 баг 1000 дээш хүн амтай байна. Аймгийн хэмжээнд нэг багт ногдох хүний тоодунджаар 699 байна.




Хүн амын тоо багуудаар авч үзвэл 1000 болон түүнээс дээш хүн амтай багуудын 5 баг нь Сайнцагаан сумын, 1 баг нь Эрдэнэдалай сумын баг байна. Аймгийн хэмжээнд хамгийн олон хүн амтай баг Сайнцагаан сумын 7-р баг 3737 хүнтэй бол хамгийн цөөн хүн амтай баг нь Цагаандэлгэр сумын 3-р

баг 204 суурин хүн амтай байна. Энэ нь иргэдийн төв суурин газар руу чиглэн суурьших сонирхол нэлээдгүй байгааг харуулж байна.

### 1.2 Хүн амын нас, хүйсийн бүтэц


2018 оны байдлаар нийт хүн амын 29.7 хувийг 0-14 насны хүүхэд, 65.1 хувийг 15-64 насныхан буюу хөдөлмөрийн насны хүн ам, 5.2 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад нийт хүн амын дунд 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувь өсч 15-64 насны хүн ам буюу хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 0.7 пунктээр буурсан харагдаж байна. Тус аймгийн хувьд хүн амын голч нас 27 байна. Энэ нь нийт хүн амын 50 хувь нь 27 наснаас дээш насныхан, 50 хувь нь 27 наснаас доош насныхан байна гэсэн утгатай юм.

Хүн амын насны бүтэц хувиар 2014-2018 он




Хүн амын хүйсийн харьцааг сүүлийн жилүүдээр харьцуулбал 2011 он хүртэл 100 эмэгтэй тутамд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.4-99.9 болж, нийт хүн амын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байсан бол 2012 оноос хойш нийт хүн амын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өсч 2018 оны эцсийн байдлаар 101.4 болсон байна. Энэ нь тус аймгийн хувьд хүйсийн харьцаанийг дүнгээрээ хэвийн байгааг харуулж байна.

Хүйсийн харьцаа 2008-2018




Хүн амын хүйсийн харьцаа аймгийн дунджаар 101.4 хувь байгаа бол Өндөршил суманд 97.6, Сайнцагаан суманд 92.2 байгаа нь тухайн сумдад эмэгтэйчүүдийн тоо илүү байгааг илтгэж байна.

### Хүйсийн харьцаа сумдаар



Хүйсийн харьцааг насны ангилал тус бүрээр тодорхой харуулсан үзүүлэлт бол нас хүйсийн суварга юм. Дараах нас хүйсийн суваргаас харвал нийт хүн амын дунд 0-4 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж хүйсийн харьцаа хэвийн байна.

Нас хүйсийн суваргын дунд хэсгээр цүлхийсэн байгаа нь нийт хүн амын дунд 15-34 насны залуучууд гол хэсгийг бүрдүүлж байна. Насны бүлэг тус бүрд хүйсийн харьцаа хэвийн байгаа бол 50 болон түүнээс дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгаа нь 50 болон түүнээс дээш насанд эрэгтэйчүүдийн нас баралт илүү байгааг харуулж байна.




### 1.3 Хүн амын дундаж наслалт

Дундаж наслалт бол хүн амын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох гол үзүүлэлт юм. Дундаж наслалт нь насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогдох үзүүлэлт байдаг. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь дундаж наслалтын ерөнхий хэмжигдэхүүн болдог.

Хүн амын дундаж наслалтын өсөлт, бууралт нь хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс шалтгаалж байдаг.


Тус аймгийн хувьд 2018 байдлаар дундаж наслалт 73.9 байгаа нь өнгөрсөн оноос 0.32-р өсч, улсын дунджаас 3.71 -ээр их байна. Дундаж наслалт 73.90 байгаа нь бусад аймаг нийслэл, бүс нутгаас хамгийн өндөр үзүүлэлт юм. Дундговь аймгийн хувьд сүүлийн 10 гаруй жил дундаж наслалт хамгийн өндөр байна.

### Дундаж наслалт 2008-2018 он



Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.78, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66.11 байна. Дундговь аймгийн хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 78.62 бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 70.82 байна

### Дундаж наслалт хүйсээр



### Хүн амын дундаж наслалт-2018 он

Аймаг/нийслэл	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Баян-Өлгий	73.11	70.31	75.36
Говь-Алтай	69.95	65.09	74.34
Завхан	70.51	67.92	73.27
Увс	69.26	64.31	73.30
Ховд	72.70	69.20	75.42
Архангай	71.37	68.63	73.08
Баянхонгор	70.01	66.98	71.85
Булган	73.44	68.76	76.41
Орхон	71.91	70.77	82.51
Өвөрхангай	70.46	67.83	73.43
Хөвсгөл	66.71	63.52	71.62
Говьсүмбэр	73.61	72.60	76.29
Дархан-Уул	68.74	64.37	74.59

Дорноговь	71.25	66.55	77.29
Дундговь	73.90	70.82	78.62
Өмнөговь	72.34	68.08	77.23
Сэлэнгэ	72.13	67.67	78.49
Төв	72.59	70.44	75.21
Дорнод	69.39	65.25	73.89
Сүхбаатар	72.66	67.58	77.75
Хэнтий	72.39	69.30	76.29
<b>Улаанбаатар</b>	<b>71.65</b>	<b>66.83</b>	<b>75.05</b>
<b>Улсын дүн</b>	<b>70.19</b>	<b>66.11</b>	<b>75.78</b>

#### 1.4 Хүн амын нягтрал

2018 оны байдлаар Улсын хэмжээнд нэг квадрат километр нутагт 2.1 хүн ногдож байгаа бол манай аймгийн хувьд 0.63 байгаа нь улсын дунджаас 1.5 дахин бага байна. Сумдаар авч үзвэл хүн амын нягтрал Сайнцагаан суманд 1км кв-т газарт 4.64 хүн ногдож байгаа бол, Өлзийт суманд 0.15 байгаа нь хамгийн бага байна. Бусад сумдын хувьд 0.3-0.86 байна.

Хүн амын нягтрал /сумдаар, оноор /

Сумд	Нягтрал			
	2015	2016	2017	2018
Дэлгэрцогт	0.63	0.65	0.67	0.68
Дэрэн	0.57	0.57	0.58	0.58
Говь-Угтаал	0.59	0.59	0.59	0.59
Цагаандэлгэр	0.30	0.30	0.31	0.31
Баянжаргалан	0.37	0.37	0.37	0.40
Өндөршил	0.30	0.30	0.30	0.30
Гурвансайхан	0.39	0.39	0.40	0.39
Өлзийт	0.15	0.15	0.15	0.15
Хулд	0.38	0.39	0.40	0.40
Луус	0.56	0.56	0.57	0.58
Дэлгэрхангай	0.35	0.36	0.37	0.37
Сайхан-Овоо	0.53	0.52	0.53	0.53
Эрдэндалай	0.77	0.77	0.77	0.79
Сайнцагаан	4.29	4.45	4.56	4.64
Адаацаг	0.86	0.86	0.89	0.88
Аймгийн дүн	0.60	0.61	0.62	0.63

## 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН, ЦЭВЭР ӨСӨЛТ

### 2.1. Төрөлт

2018 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 78444 хүүхэд төрсөн бол Дундговь аймгийн хувьд үүний 1.5 хувьбуюу 1192 төрөлт бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 166 төрөлтөөр буюу 16.2 хувиар

өссөн байна. Сумдаар авч үзвэл Өлзийт, Адаацаг сумдад төрөлт 12.3-21.1 хувиар буурсан бол бусад бүх сумдад 2.0-29.5 хувиар өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн 97.2 хувь нь эмнэлэгт төржээ.

### Төрсөн хүүхдийн тоо 2014-2018


Сумд	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Дэлгэрцогт	33	42	35	37	48
Дэрэн	50	59	46	44	52
Говь-Угтаал	36	42	29	30	40
Цагаандэлгэр	28	20	28	15	22
Баянжаргалан	28	22	32	31	33
Өндөршил	27	22	31	25	26
Гурвансайхан	45	45	42	42	42
Өлзийт	52	62	54	52	41
Хулд	48	63	68	64	67
Луус	35	45	39	38	57
Дэлгэрхангай	43	55	40	54	68
Сайхан-Овоо	42	48	55	39	42
Эрдэндалай	126	153	143	144	152
Сайнцагаан	373	357	397	338	438
Адаацаг	65	60	68	73	64
<b>Аймгийн дүн</b>	<b>1031</b>	<b>1095</b>	<b>1107</b>	<b>1026</b>	<b>1192</b>

Төрсөн хүүхдүүдийн 52.1 хувь буюу 621 нь эрэгтэй, 47.9 хувь буюу 571 нь эмэгтэй хүүхдүүд байна. Эндээс үзэхэд төрөх үеийн хүйсийн харьцаа:

$$ТҮХХ = \frac{B1}{B2} * 100 \text{ буюу } \frac{621}{571} * 100 = 108.7$$


Энэ нь 100 эмэгтэй хүүхэд төрөх тутамд 109 эрэгтэй хүүхэд төрж байгааг харуулсан үзүүлэлт юм.

### ТӨРСӨН ХҮҮХЭД ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Аймгийн хэмжээнд 1000 хүнд ногдох төрөлт 25.8 байгаа бол Сайнцагаан, Дэлгэрхангай, Хулд, Луус, Дэлгэрцогт сумд дунджаас өндөр үзүүлэлттэй байна. 1000 хүнд ногдох төрөлт хамгийн бага сумд нь Өлзийт, Сайхан-Овоо, Өндөршил, Гурвансайхан сумд байна.

### 1000 хүнд ногдох төрөлт 2018 он




2018 оны байдлаар төрөлтийн тусгай коэффициент 100.1 байгаа нь нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд 100 төрөлт бүртгэгдэж байгааг харуулж байна. Тухайн онд 15-49 насны эмэгтэйчүүдийн 10 хувь нь хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос 1.5 хувиар өссөн байна.

$$TEK = \frac{\text{амьд төрсөн хүүхдийн тоо}}{\text{жилийн дундаж хүн ам}} * 1000 = \frac{1192}{46602} * 1000 = 25.6$$


$$TTK = \frac{\text{амьд төрсөн хүүхдийн тоо}}{15-49 \text{ насны эмэгтэйчүүд}} * 1000 = \frac{1192}{11906} * 1000 = 100.1$$

1000 хүнд ногдох төрөлт буюу төрөлтийн ерөнхий коэффициент 25.6 болж өмнөх оны мөн үеэс 3.3пунктээр өссөн, мөн 1000 хүнд ногдох нас баралт 6.7 болж өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн байна. Төрөлт нас баралтаар тодорхойлогддог хүн амын ердийн хөдөлгөөний коэффициент 18.9 болж өмнөх оноос 1.9 пунктээр өссөн нь 1000 хүнд ногдох ердийн өсөлт 19 байгааг харуулж байна.




**Амаржсан эх:** Нийт төрсөн эхчүүдийн 60.8% буюу 725 нь 20-29 насныхан, 30.5% буюу 366 нь 30-39 насныхан, 6.8 % буюу 81 нь 19 хүртэлх насныхан байгаа бол, 40 болон түүнээс насны 23 эх амаржиж нийт төрөлтийн 1.9 хувийг бүрдүүлж байна. Төрөлтийн дундаж нас 24 байна.

## Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд насны бүлгээр




Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн насны бүлэг тус бүрээр төрөлтийн коэффициентийг харуулбал, 25-29 насны 1000 эмэгтэй тутмын 95 нь, 20-24 насны 1000 эмэгтэй тутмын 94 нь 30-34 насны 1000 эмэгтэй тутмын 67 нь хүүхэд төрүүлсэн байна.

## Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент




Амаржсан эхчүүдийг гэрлэлтийн байдлаар авч үзвэл 47.0% нь батлуулсан гэр бүлтэй, 35.7% нь батлуулаагүй гэр бүлтэй байгаа бол 15.7% нь огт гэр бүл болоогүй, 1.6 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан, тусгаарласан болон бэлэвсэн эмэгтэйчүүд байна.

## Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд гэрлэлтийн байдал



Амаржсан эмэгтэйчүүдийг боловсролын түвшингээр харуулбал 45.5 хувь нь бүрэн дунд, 25.8 хувь нь бакалавр болон түүнээс дээш боловсролтой, 15.4 хувь нь суурь боловсролтой, 5.1 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 5.7 хувь нь бага, 2.4 хувь нь боловсролгүй байна.

## Амаржсан эхчүүд боловсролын түвшингээр



## 2.2 Нас баралт


Тухайн онд улсын хэмжээнд 17864 хүн нас барсан бол Дундговь аймгийн хувьд 313 хүн нас барсан нь нийт нас баралтын 1.75 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо өнгөрсөн оноос 62 тохиолдол буюу 24.7 хувиар өссөн байна.

Нас барсан хүний тоо 2014-2018 он

Сумд	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Дэлгэрцогт	33	42	35	37	48
Дэрэн	50	59	46	44	52
Говь-Угтаал	36	42	29	30	40
Цагаандэлгэр	28	20	28	15	22
Баянжаргалан	28	22	32	31	33
Өндөршил	27	22	31	25	26
Гурвансайхан	45	45	42	42	42
Өлзийт	52	62	54	52	41
Хулд	48	63	68	64	67
Луус	35	45	39	38	57
Дэлгэрхангай	43	55	40	54	68
Сайхан-Овоо	42	48	55	39	42
Эрдэндалай	126	153	143	144	152
Сайнцагаан	373	357	397	338	438
Адаацаг	65	60	68	73	64
<b>Аймгийн дүн</b>	<b>1031</b>	<b>1095</b>	<b>1107</b>	<b>1026</b>	<b>1192</b>


Аймгийн дунджаар 1000 хүнд ногдох нас баралт 6.7 байхад Дэлгэрхангай 10.9, Луус-8.67, Дэлгэрцогт-8.3 байгаа нь нас баралт ихтэй, Өндөршил-3.52, Хулд 3.72, Сайхан-Овоо 3.69 байгаа нь нас баралтын түвшин хамгийн багатай сумд байна.

1000 хүнд ногдох нас баралт-2018




Нас барсан хүн амын 196 буюу 62.6 хувийг эрэгтэйчүүд, 103 буюу 37.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэдгээрийн дунд 0-14 насны 15, 15-64 насны 165, 65-аас дээш насны 133 иргэн нас баржээ.

Нас барсан хүн ам насны бүлгээр, хүйсээр



Нас барсан иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл 31.6 хувь нь бага боловсролтой, 20.1 хувь нь суурь боловсролтой, 19.8 хувь нь бүрэн дунд боловсролтой, 7.0 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 7.3 хувь нь дээд боловсролтой 14.0 хувь нь боловсролгүй иргэд байна.


Нас барсан хүн боловсролын түвшингээр



Нас баралтын ерөнхий коэффициент 5.7 байгаа 1000 хүн тутамд 6-7 хүн нас барж байгааг харуулж байна.

$$\text{НБЕК} = \frac{\text{Нас барсан хүний тоо}}{\text{Жилийн дундаж хүн ам}} * 1000 = \frac{313}{46602} * 1000 = 6.1$$

Нас барсан хүн амын 63 хувь болох 196 нь орон гэртээ, 26 хувь нь буюу 83 нь эмнэлэгт, 2 хүн хээр гадаа, бусад газарт 32 нь нас барсан байна.




### 2.3 Гэрлэлт, цуцлалт үрчлэлт

Улсын хэмжээнд 21020 гэрлэлт бүртгэгдсэн. Аймгийн хэмжээнд 235 гэрлэлт бүртгэгдсэнээс 234 нь шинээр бүртгүүлж, 1 нь гэрлэлтээ сэргээсэн байна. Гэрлэлт өнгөрсөн оноос 14 тохиолдол буюу 5.6 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд гэрлэлтийн ерөнхий коэффициент 5.4 байгаа нь 1000 хүн тутамд 5 гэрлэлт бүртгэгдэж байгааг харуулж байна


$$\text{ГЕК} = \frac{\text{Нийт гэрлэлт}}{\text{Жилийн дундаж хүн ам}} * 1000 = \frac{234}{46602} * 1000 = 5.0$$

Гэрлэлтээ бүртгүүлсэн хүмүүсийн 72.2 хувь нь 20-29 насныхан, 18.2 хувь нь 30-39 насныхан, 5.6 хувь нь 40 дээш насныхан байгаа бол, 4 хувь нь 16-19 насныхан байна. 16-19 насныхны 78.9 хувийг эмэгтэйчүүд 21.1 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Эмэгтэйчүүдийн ихэнх хэсэг нь 20-24 насандаа гэрлэсэн бол, эрэгтэйчүүдийн ихэнх хувь нь 25-29 насандаа гэрлэж байна.




Гэр бүлээ бүртгүүлсэн иргэдийн 435 нь буюу 93.0 хувь анх удаа гэрлэж, 7 хувь нь дахин гэрлэсэн байна.

### ГЭРЛЭЛТИЙН ӨМНӨХ СТАТУС




### ГЭРЛЭЛТ 2008-2018 ОНД




**Цуцлалт:** Улсын хэмжээнд 4021 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өнгөрсөн оноос 1.9 хувиар буюу 76 цуцлалтаар нэмэгдсэн байна. Дундговь аймгийн хэмжээнд 43 цуцлалт бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 43.3 хувь буюу 13 тохиолдлоор өссөн байна. Гэрлэлтээ дуусгавар болгосон иргэдийн 15.8 хувь нь 20-29 насныхан, 25.7 хувь нь 30-39 насныхан, 13.2 хувь нь 40-49 насныхан, 2.0 хувь нь 50-аас дээш насныхан байна.


### Гэрлэлтээ дуусгавар болгосон хүний тоо, хүйсээр



Гэрлэлтээ цуцлуулсан гэр бүлийн 30 хувь буюу 13 нь 10-14 жил, 23.3 хувь буюу 10 нь 7-9 жил, мөн 10 нь 20 болон түүнээс дээш жил, 6 нь 1-6 жил хамт амьдарсан байна.




### ЦУЦЛАЛТЫН ТОО



**Үрчлэлт:** 2018 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 1549 хүүхэд үрчлэгдэж өмнөх оноос 10.9 хувиар буурчээ. Аймгийн хэмжээнд 9 хүүхэд үрчлэгдсэн. Үрчлэлт өмнөх оны мөн үеэс 55.0 хувиар буурсан. Үрчлэгдсэн хүүхдүүдийн 6 нь эмэгтэй, насны бүлгээр авч үзвэл 55.5 хувь нь 0-3 настай, 11.1 хувь нь 3-6 настай, 33.3 нь 10 дээш настай хүүхэд байна.

### Үрчлэгдсэн хүүхэд насны бүлгээр




### 3. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2018оны жилийн эцсийн байдлаар тус аймаг нийт 638хүн шилжин ирсэн нь өнгөрсөн оноос 169 хүнээр буюу 20.9 хувиар буурсан байна. Шилжиж ирсэн хүний 49.1 хувийг эмэгтэйчүүд, 50.9 хувийг эрчүүд эзэлж байна.

Нийт шилжиж ирсэн хүн амыг насны бүлгээр ангилбал 32.1 хувь нь 0-14 насны, 62.7 хувийг 54 насны хүн ам, 5.2 хувийг 55 болон түүнээс дээш насныхан эзэлж байна.

## Шилжин ирсэн хүн ам



Шилжин ирэгчдийн урсгалыг харуулвал:


-Улаанбаатар хотоос-298, Өмнөговь аймгаас-62, Говьсүмбэр аймгаас 66, Төв аймгаас-65, Дорноговь аймгаас-27, Өвөрхангай аймгаас-15 хүн тус тус шилжин ирсэн бол үлдсэн 16 хувь буюу 100 хүн бусад аймгаас шилжин ирсэн байна.

## Шилжин ирсэн хүн ам




2018 онд тус аймгаас өөр аймаг нийслэл руу нийт 595 хүн шилжсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.3 хувиар өссөн байна. Шилжин явсан хүн амын 48.6 хувийг эмэгтэйчүүд, 51.4 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Шилжин явсан хүн амын 32.4 хувийг 0-14 насны хүүхэд, 62.4 хувийг 15-54 насныхан, 5.2 хувийг 55 болон түүнээс дээш насныхан бүрдүүлж байна.

## Шилжин явсан хүний тоо насны бүлгээр



Шилжин явсан хүн амын урсгалыг харуулбал:

-Улаанбаатар хотруу 268, Өмнөговь аймагруу62, Говьсүмбэр аймагруу 66, Төв аймагруу 64 Дорноговь аймагруу 24, Өвөрхангай аймагруу 12 хүн тус тус шилжиж, үлдсэн 17.0 хувь буюу 99 хүн бусад аймгуудруу шилжин явжээ.



2018 оны байдлаар шилжин ирэлтийн коэффициент өнгөрсөн оноос 3.9пунктээрбуурч13.7, шилжин явалтын коэффициент 0.1пунктээр буурч 12.8 болсноор цэвэр шилжилтийн коэффициент 0.9болжээ. Тус аймгийн хувьд цэвэр шилжилтийн коэффициент тогтмол (-) буюу сөрөг гарч хүн амын тооны бууралтад гол нөлөөлдөг хүчин зүйл байсан бол, 2017, 2018 онуудад (+) эерэг гарч байна. Энэ нь 1000 хүн тутам 13 хүн шилжин явж, 14 хүн шилжиж ирж байна гэсэн утгыг харуулж байна.

**Цэвэр шилжилтийн коэффициент  
2008-2018 онуудаар**



2008-2018 оны хугацаанд Дундговь аймгаас нийт 15656 хүн өөр аймаг нийслэлрүү шилжин явсан бол 5411 хүн шилжин ирсэн байна.

**Хүн амын шилжилт хөдөлгөөний коэффициент**

Он	Хүн ам	Шилжиж ирсэн хүн ам	Шилжиж явсан хүн ам	Шилжин ирэлтийн коэф	Шилжин явалтын коэф	Цэвэр шилжилтийн коэф
2008	47959	240	1619	5.0	33.4	-28.4
2009	47622	230	1876	4.8	39.3	-34.4
2010	45914	211	2432	4.5	52.0	-47.5
2011	45048	220	1785	4.8	39.2	-34.4
2012	44601	285	1370	6.4	30.6	-24.2
2013	44400	618	1629	13.9	36.6	-22.7
2014	44207	669	1450	15.1	32.7	-17.6

2015	44926	792	1152	17.8	25.8	-8.1
2016	45515	701	1155	15.5	25.5	-10.0
2017	46383	807	593	17.6	12.9	4.7
2018	46820	638	595	13.7	12.8	0.9

#### 4. ӨРХ, ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

##### 4.1 Өрх, өрхийн бүтэц, өсөлт


2018 оны эцсээр нийт өрхийн тоо 14863 болж өмнөх оноос 307 өрхөөр буюу 2.1 хувиар өслөө. Өрхийн тоо өссөнөөр нэг өрхөд ногдох хүн амын тоо буурч 3.15 болжээ.



Хөдөөд 8158 өрхийн 25584 хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 54.9% юм. Аймгийн төвд 3832 өрхийн 12433 хүн амьдарчбайгаа нь нийт өрхийн 25.8%, сумын төвд 2873 өрхийн 8803 хүн амьдарч байгаа нь 19.3 хувь байна.


Аймгийн хэмжээнд 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 504 байгаагийн 102 нь аймгийн төвд, 92 нь сумын төвд, 310 нь хөдөөд байна.

##### 18 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо



Нийт өрхийн 75.0 хувь буюу 11150 нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 25.0 хувь буюу 3713 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. 2018 онд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо буурч, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 1 ам бүлтэй өрхийн тоо нэмэгдэж 3401 буюу нийт өрхийн 23.0, 2-4 ам бүлтэй өрхийн тоо 7931 болж нийт өрхийн 54 хувь, 5-7 ам бүлтэй өрхийн тоо 3324 буюу нийт өрхийн 22.0 хувь, 8-10 ам бүлтэй өрхийн тоо 177 буюу 1.2 хувийг бүрдүүлж байна.



#### 4.2 Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтүүд


2018 оны эцсийн байдлаар өнчин хүүхдийн тоо 489 болж өнгөрсөн оноос 67 хүүхдээр нэмэгдсэн бөгөөд тэдгээрийн 453 буюу 92.6 хувь нь хагас өнчин, 7.4 хувь буюу 36 нь бүтэн өнчин хүүхэд байна.

Өнчин хүүхдийн тоо 2014-2018



Өнчин хүүхдүүдийн 51.9 хувь болох 254 нь эмэгтэй хүүхэд байна. Тэдгээрийн 38.2 хувь нь 10-14 настай, 28.4 хувь нь 15-17 настай, 25.8 хувь нь 5-9 настай бол 7.6 хувь нь 0-4 насны хүүхдүүд байна.

Өнчин хүүхдийн тоо насны бүлгээр, үүнээс эмэгтэй




**Өрх толгойлсон эцэг эх:** Гэр бүлгүй өрх толгойлсон хүний тоо 2401 байгаагийн 79.7 хувь нь эмэгтэй, 20.3 хувь нь өрх толгойлсон эрчүүд байна. Нийт өрх толгойлсон хүний 44.3 хувь буюу 1068 нь 18 хүртэлх насны хүүхэдтэй хүн байна. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүний тоо 1068 болж өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар буурсан бол эдгээрийн 90.4 хувь нь эмэгтэйчүүд 9.6 хувь нь эрэгтэйчүүд байна.

### Өрх толгойлсон эцэг эх




18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүний 32.0 хувь нь аймгийн төвд, 29.9 хувь нь сумын төвд, 37.3 хувь нь хөдөөд амьдарч байна.


### 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, хүйсээр байршлаар




Нийт өрх толгойлсон хүмүүсийн 750 нь 1-2 хүүхэдтэй, 245 нь 3-5 хүүхэдтэй, 72 нь 6 болон түүнээс дээш хүүхэдтэй байна.



**Ганц бие өндөр настан:** Ганц биеэр амьдарч байгаа ахмад настны тоо 1070 болж өнгөрсөн оноос 41-ээрэсжээ. Тэдгээрийн 755 нь буюу 72.4 хувь нь 55-с дээш насны эмэгтэйчүүд, 315 нь буюу 27.6 хувь нь 60-с дээш насны эрэгтэйчүүд байна.



**Ихэр хүүхэд:** 2018 оны байдлаар 118 өрхийн 237 ихэр хүүхэд байгаагийн 117 нь 2 ихэр, 1 нь 3 ихэр хүүхэдтэй өрх байна. Ихэр хүүхэдтэй өрхийн тоо өнгөрсөн оноос 8 –р өссөн байна. Ихэр хүүхэдтэй өрх нь Сайнцагаан суманд 38, Эрдэнэдалай суманд 13, Өлзийт суманд 8, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Гурвансайхан сумдад тус бүр 7 байгаа нь хамгийн олон ихэр хүүхэдтэй сумдууд байна.




**Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:** 2018 оны эцсээр аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1826 хүн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 хувиар буурчээ. Тэдгээрийн 42.2 хувь нь /770/ эмэгтэйчүүд, 10,4 хувь нь /1056/ эрэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 7.7 хувийг 0-14 насны хүүхэд, 88.1 хувийг 15-64 насныхан, 4.3 хувийг 65 болон түүнээс дээш насныхан эзэлж байна.




Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 12.9 хувь буюу 235 иргэн ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхэлж байна. Өвчний хэлбэрээр авч үзвэл харааны бэрхшээлтэй иргэдийн 15.2, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн 18.5, Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн 18.1, ярианы бэрхшээлтэй иргэдийн 12.1, Хавсарсан төрлийн бэрхшээлтэй иргэдийг 8.5, сэтгэцийн төрлийн бэрхшээлтэй иргэдийн 5.3 хувь, бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 14.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар




Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 24.8 хувийг сэтгэц, 22.9 хувийг хөдөлгөөн, 10.8 хувийг ярианы, 6.8 хувийг сонсголын, 5.8 хувийг хавсарсан, 3.6 хувийг хэл ярианы бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

### Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр, үүнээс эмэгтэй



Хөгжлийн бэрхшээлийг төрлөөр авч үзвэл 50 хувь нь төрөлхийн, 35 хувь нь ердийн өвчний улмаас, 6 хувь нь ахуйн ослоор, 5 хувь нь зам тээврийн ослоор, 3 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр, 1 хувь нь үйлдвэрлэлийн ослоор хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.




Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Бүтэн өнчин хүүхдийн тоо	37	32	32	32	36
Хагас өнчин хүүхдийн тоо	437	438	437	390	453
18 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо	1242	938	1041	1136	1068
18 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй эхийн тоо	1062	826	925	1021	965
18 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй эцгийн тоо	180	112	116	115	103
Өрх толгойлсон гэр бүлгүй хүний тоо	2751	2340	2436	2405	2401
-эмэгтэй	2068	1749	1846	1890	1913
-эрэгтэй	683	591	590	515	488
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	1982	1837	1747	1830	1826
- эрэгтэй	1156	1043	1004	1044	1056
-эмэгтэй	826	794	743	786	770
Бүгдээс төрөлхийн	785	991	800	871	926
-олдмол	1197	846	947	959	900
Ганц бие өндөр настан	827	1015	1103	1029	1070

### Алдарт эхийн одонтой эхчүүд:

2018 оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд алдарт эхийн 1 болон 2 дугаар одонтой эхийн тоо 4080 эмэгтэй байгаагийн 1527 нь эхийн 1-р одонтой, 2553 нь эхийн 2-р одонтой эхчүүд байна.

Алдарт эхийн одонтой эхчүүд



Алдарт эхийн одонтой эхчүүдийн 0.76 хувь нь 20-29 насны, 10.4 хувь нь 30-39 насны, 18,4 хувь нь 40-49 насны, 28.5 хувь нь 50-59 насны, 42.7 хувь нь 60 болон түүнээс дээш насны эмэгтэйчүүд байна.

Одонтой эхчүүдийн 30.7 хувь буюу 1252 нь Сайнцагаан суманд, 13.5 хувь буюу 549 нь Эрдэнэдалай суманд, 6.8 хувь буюу 278 нь Адаацаг суманд, 5.3 хувь буюу 216 нь Дэрэн суманд, 5.1 хувь нь Хулд суманд амьдарч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлтүүд байна.

### Алдарт эхийн одонтой эмэгтэйчүүд насны бүлгээр

Насны бүлэг	2-р одонтой эхчүүд	1-р одонтой эхчүүд	Нийт
25 хүртэлх	1	0	1
25-29	27	3	30
30-34	128	4	132
35-39	275	17	292
40-44	366	27	393
45-49	306	51	357
50-54	421	95	516
55-59	440	208	648
60-64	306	301	607
65-69	130	281	411
70-74	58	183	241
75-79	35	159	194
80-84	28	124	152
85-89	18	61	79
90-94	13	10	23
95+	1	3	4
<b>Бүгд</b>	<b>2553</b>	<b>1527</b>	<b>4080</b>




## ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨРХ, ХҮН АМЫН МЭДЭЭЛЭЛ

2017

2018

	2017	2018	
 ХҮН АМЫН ТОО	46 383	46 820	
 ӨРХИЙН ТОО	14 556	14 863	
 ТӨРӨЛТИЙН ТОО	1 026	1 192	
 НАС БАРАЛТ ТОО	251	313	
 ГЭРЛЭЛТИЙН ТОО	248	234	
 ЦУЦЛАЛТЫН ТОО	30	43	
 ҮРЧЛЭЛТИЙН ТОО	20	9	
 ШИЛЖИН ИРЭЛТ	807	638	
 ШИЛЖИН ЯВАЛТ	593	595	
 ДУНДАЖ НАСЛАЛТ	73.6	73.9	



### 4.3 Хавсралт хүснэгтүүд

Хүн амын тоо, хүйсээр, байршлаар-2018 он

Сумд	Бүх хүн ам			Аймаг, сумын төвд,			Хөдөөд		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Сайнцагаан	15762	7562	8200	12433	5855	6578	3329	1707	1622
Адаацаг	2888	1503	1385	521	260	261	2367	1243	1124
Баянжаргалан	1276	682	594	545	283	262	731	399	332
Говь-Угтаал	1586	826	760	572	294	278	1014	532	482
Гурвансайхан	2093	1063	1030	364	172	192	1729	891	838
Дэлгэрхангай	2291	1161	1130	1010	510	500	1281	651	630
Дэлгэрцогт	1694	876	818	531	269	262	1163	607	556
Дэрэн	2105	1079	1026	482	247	235	1623	832	791
Луус	1864	978	886	654	344	310	1210	634	576
Өлзийт	2363	1293	1070	425	223	202	1938	1070	868
Өндөршил	1421	702	719	386	172	214	1035	530	505
Сайхан-Овоо	2156	1112	1044	695	361	334	1461	751	710
Хулд	2416	1225	1191	866	440	426	1550	785	765
Цагаандэлгэр	1058	555	503	514	268	246	544	287	257
Эрдэнэдалай	5847	2952	2895	1238	596	642	4609	2356	2253
<b>Нийт</b>	<b>46820</b>	<b>23569</b>	<b>23251</b>	<b>21236</b>	<b>10294</b>	<b>10942</b>	<b>25584</b>	<b>13275</b>	<b>12309</b>

Хүн амын тоо насны бүлгээр, сумдаар -2018

Сумд	Нийт хүн ам	0-14 нас	15-64 нас	65 дээш
Адаацаг сум	2888	859	1899	130
Баянжаргалан сум	1276	399	800	77
Говь-Угтаал сум	1586	452	1057	77
Гурвансайхан сум	2093	559	1417	117
Дэлгэрхангай сум	2291	698	1475	118
Дэлгэрцогт сум	1694	488	1101	105
Дэрэн сум	2105	618	1365	122
Луус сум	1864	528	1255	81
Өлзийт сум	2363	627	1628	108
Өндөршил сум	1421	371	970	80
Сайнцагаан сум	15762	4884	10057	821
Сайхан-Овоо сум	2156	611	1442	103
Хулд сум	2416	694	1608	114
Цагаандэлгэр сум	1058	312	688	58
Эрдэнэдалай сум	5847	1823	3708	316
<b>Нийт</b>	<b>46820</b>	<b>13923</b>	<b>30470</b>	<b>2427</b>

### Хүн амын тоо багаар-2018

Байр	Сум	Багийн нэр	хүн ам	Байр	Сум	Багийн нэр	хүн ам
1	СЦ	7-р баг, Нарлаг	3737	35	ДХ	4-р баг, Номгон	543
2	СЦ	9-р баг, Мандал	2787	36	ДЦ	3-р баг, Дэлгэр-Эмг	531
3	СЦ	8-р баг, Айраг	2091	37	ӨЛ	5-р баг, Дэрт-2	529
4	СЦ	6-р баг, Боржигон	1947	38	ӨШ	2-р баг, Талын нар	526
5	СЦ	5-р баг, Аривжих	1871	39	СО	3-р баг, Найз	525
6	ЭД	7-р баг, Сумын төв	1238	40	ДХ	2-р баг, Таргат	522
7	СЦ	3-р баг, Далай	950	41	АД	1-р баг, Тавин	521
8	ЭД	4-р баг, Рашаант	914	42	СО	4-р баг, Төгрөг	517
9	ЭД	6-р баг, Сангийн далай	907	43	АД	3-р баг, Өвөр-Урт	509
10	ЭД	5-р баг, Цагаан-Овоо	831	44	ӨШ	1-р баг, Цог	509
11	СЦ	4-р баг, Үйзэн	815	45	ЛС	3-р баг, Зүлэгтий	506
12	СЦ	2-р баг, Тэвш	803	46	ГС	2-р баг, Дэрсэнэ ус	503
13	СЦ	1-р баг, Наран	761	47	ДН	3-р баг, Долоод	501
14	ЛС	1-р баг, Суварга	748	48	ХД	1-р баг, Шувуутай	482
15	ЭД	2-р баг, Өнгөт	711	49	ГС	3-р баг, Чулуут	473
16	ХД	2-р баг, Олдох	704	50	СО	2-р баг, Мааньт	468
17	ЭД	1-р баг, Цавчир	683	51	ДН	4-р баг, Бумбат	466
18	АД	5-р баг, Хашаат	682	52	БЖ	2-р баг, Энгэр-Ус	453
19	СО	1-р баг, Онги	646	53	ГУ	3-р баг, Хонгор	448
20	ХД	3-р баг, Уул	644	54	ӨЛ	2-р баг, Буянт-2	436
21	ДХ	1-р баг, Толь	633	55	ӨЛ	6-р баг, Рашаант	425
22	ЛС	2-р баг, Наран	610	56	Өш	3-р баг, Бөхт	386
23	АД	4-р баг, Сүм	608	57	ГС	4-р баг, Гурвансайхан	384
24	ДХ	3-р баг, Ар шавагтай	593	58	ГС	1-р баг, Элгэн	369
25	ХД	4-р баг, Бүлээн	586	59	ГС	5-р баг, Суугаант	364
26	ДЦ	2-р баг, Цахиурт	584	60	Өл	1-р баг, Буянт-1	349
27	ДЦ	1-р баг, Баянбулаг	579	61	ЦД	1-р баг, Хараат	334
28	ДН	1-р баг, Алаг-Өндөр	576	62	ӨЛ	3-р баг, Тагт	317
29	ГУ	2-р баг, Морьт	572	63	ӨЛЗИ	4-р баг, Дэрт-1	307
30	АД	2-р баг, Ар-Урт	568	64	ЦД	4-р баг, Замын-Улаан	298
31	ГУ	1-р баг, Ажирхай	566	65	БЖ	1-р баг, Шилийн гол	278
32	ЭД	3-р баг, Тэнгэлэг	563	66	ЦД	2-р баг, Дэлгэрэх зам	222
33	ДН	2-р баг, Саруул	562	67	ЦД	3-р баг, Жаргалант	204
34	БЖ	3-р баг, Аргатай	545	Бүгд			46820

### Шинэ төрсөн хүүхдийн тоо эхийн насны бүлгээр -2018

Сумд	Төрсөн хүүхдийн тоо	Эхийн насны бүлгээр							
		15 хүрт:	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45+
Адаацаг	64	0	8	25	16	11	4	0	0
Баянжаргалан	33	0	0	10	9	10	4	0	0
Говь-Угтаал	40	0	4	13	10	10	3	0	0
Гурвансайхан	42	0	2	14	15	6	5	0	0
Дэлгэрхангай	68	0	2	24	19	16	7	0	0
Дэлгэрцогт	48	0	3	10	15	11	7	2	0
Дэрэн	52	0	3	20	11	7	11	0	0
Луус	57	0	4	17	13	16	6	1	0
Өлзийт	41	0	5	11	12	11	2	0	0
Өндөршил	26	0	1	9	6	6	4	0	0
Сайнцагаан	438	1	22	130	152	85	36	12	0
Сайхан-Овоо	42	0	6	13	12	6	3	2	0
Хулд	67	1	6	22	18	8	9	3	0
Цагаандэлгэр	22	0	2	7	5	6	2	0	0
Эрдэнэдалай	152	0	11	50	37	30	21	3	0
<b>Нийт</b>	<b>1192</b>	<b>2</b>	<b>79</b>	<b>375</b>	<b>350</b>	<b>239</b>	<b>124</b>	<b>23</b>	<b>0</b>

Амаржсан эхчүүд боловсролын түвшингээр-2018

Сумд	Амаржсан эхчүүд	Боловсролын түвшингээр								
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Диплом болон бакалаврын дээд	Магистр	Доктор
Адаацаг	64	3	7	17	24	2	1	10	0	0
Баянжаргалан	33	0	4	7	14	1	1	6	0	0
Говь-Угтаал	40	1	1	7	19	2	2	7	0	1
Гурвансайхан	42	1	1	9	11	7	0	13	0	0
Дэлгэрхангай	68	1	5	13	30	2	0	17	0	0
Дэлгэрцогт	47	0	5	10	22	0	1	9	0	0
Дэрэн	52	1	7	5	23	3	1	9	3	0
Луус	56	0	5	6	19	8	3	15	0	0
Өлзийт	41	1	3	7	21	1	1	7	0	0
Өндөршил	26	0	1	6	12	1	1	5	0	0
Сайнцагаан	437	17	6	30	240	2	3	130	4	5
Сайхан-Овоо	42	0	4	7	20	1	1	9	0	0
Хулд	67	1	2	12	29	3	1	19	0	0
Цагаандэлгэр	22	0	0	2	9	0	3	7	0	1
Эрдэнэдалай	152	3	17	45	48	3	6	30	0	0
<b>Нийт</b>	<b>1189</b>	<b>29</b>	<b>68</b>	<b>183</b>	<b>541</b>	<b>36</b>	<b>25</b>	<b>293</b>	<b>7</b>	<b>7</b>

Амаржсан эхчүүд гэрлэлтийн байдлаар-2018

Сумд	Амаржсан эхчүүд	Гэрлэлтийн байдал					Бэлэвсэн
		Огт гэрлээгүй	Гэрлэсэн батлуулсан	Гэрлэсэн батлуулаагүй	Тусгаарласан	Гэрлэлтээ дуусгаар бо	
Адаацаг	64	14	38	10	2	0	0
Баянжаргалан	33	6	21	5	0	1	0
Говь-Угтаал	40	3	20	17	0	0	0
Гурвансайхан	42	6	26	10	0	0	0
Дэлгэрхангай	68	11	37	20	0	0	0
Дэлгэрцогт	47	5	28	14	0	0	0
Дэрэн	52	3	26	23	0	0	0
Луус	56	5	32	17	1	0	1
Өлзийт	41	3	18	20	0	0	0
Өндөршил	26	7	11	8	0	0	0
Сайнцагаан	437	85	180	166	0	6	0
Сайхан-Овоо	42	7	22	12	0	1	0
Хулд	67	10	32	25	0	0	0
Цагаандэлгэр	22	1	14	7	0	0	0
Эрдэнэдалай	152	21	60	71	0	0	0
<b>Нийт</b>	<b>1189</b>	<b>187</b>	<b>565</b>	<b>425</b>	<b>3</b>	<b>8</b>	<b>1</b>

Нас барсан хүний тоо, хүйсээр, боловсролын түвшингээр

Сумд	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Боловсролын түвшингээр						
				Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Диплом болон бакалаврын дээд
Адаацаг	21	12	9	5	8	4	1	2	0	1
Баянжаргалан	9	5	4	3	2	3	0	1	0	0
Говь-Угтаал	12	7	5	2	3	2	3	0	0	2
Гурвансайхан	16	11	5	3	8	4	0	1	0	0
Дэлгэрхангай	25	18	7	3	11	8	1	1	0	1
Дэлгэрцогт	14	10	4	1	7	4	0	2	0	0
Дэрэн	11	6	5	0	5	2	4	0	0	0
Луус	16	11	5	2	3	7	2	1	0	1
Өлзийт	13	9	4	2	6	1	2	0	0	2
Өндөршил	5	2	3	0	2	1	2	0	0	0
Сайнцагаан	111	70	41	14	21	17	40	3	5	11
Сайхан-Овоо	8	7	1	1	4	0	1	0	0	2
Хулд	9	6	3	1	3	2	0	1	0	2
Цагаандэлгэр	7	3	4	2	2	0	3	0	0	0
Эрдэнэдалай	36	19	17	5	14	8	3	2	3	1
<b>Нийт</b>	<b>313</b>	<b>196</b>	<b>117</b>	<b>44</b>	<b>99</b>	<b>63</b>	<b>62</b>	<b>14</b>	<b>8</b>	<b>23</b>

Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт сумдаар 2016-2018

Сумд	Гэрлэлт			Цуцлалт			Хүүхэд үрчлэлт		
	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Дэлгэрцогт	6	8	8	1	1	0	0	0	0
Дэрэн	12	8	15	0	0	0	0	1	0
Говь-Угтаал	1	4	4	0	0	1	2	1	0
Цагаандэлгэр	1	2	1	0	0	0	0	0	0
Баянжаргалан	9	8	3	2	0	1	0	0	0
Өндөршил	5	9	4	0	1	0	0	0	0
Гурвансайхан	9	14	13	4	3	1	0	0	0
Өлзийт	13	8	13	0	0	4	2	0	2
Хулд	7	12	9	0	3	1	1	1	0
Луус	10	19	9	1	0	1	0	1	1
Дэлгэрхангай	5	8	8	1	2	0	0	3	2
Сайхан-Овоо	5	10	8	0	1	1	0	0	1
Эрдэнэдалай	7	18	20	3	3	3	7	2	1
Сайнцагаан	58	89	97	19	13	29	8	9	1
Адаацаг	21	31	22	1	3	1	1	2	1
Дүн	169	248	234	32	30	43	21	20	9

Алдарт эхийн одонтой эхчүүд сумдаар-2018

Сумд	2-р одонтой эхчүүд	1-р одонтой эхчүүд	Нийт
Дэлгэрцогт	96	61	157
Дэрэн	120	96	216
Говь-Угтаал	96	49	145
Цагаандэлгэр	71	37	108
Баянжаргалан	65	49	114
Өндөршил	63	63	126
Гурвансайхан	120	64	184
Өлзийт	124	75	199
Хулд	149	58	207
Луус	124	48	172
Дэлгэрхангай	128	68	196
Сайхан-Овоо	105	72	177
Эрдэнэдалай	351	198	549
Сайнцагаан	779	473	1252
Адаацаг	162	116	278
Бүгд	2553	1527	4080

Нийт ерхийн тоо сумдаар, байршлаар-2018

Аймаг	Өрх - Бүгд	Үүнээс		
		Аймгийн төвд	Сумын төвд	Хөдөөд
Сайнцагаан	4868	3732	0	989
Адаацаг	867	0	350	520
Баянжаргалан	443	0	161	251
Говь-Угтаал	537	0	259	282
Гурвансайхан	684	0	213	465
Дэлгэрхангай	718	0	315	395
Дэлгэрцогт	583	0	199	375
Дэрэн	637	0	171	454
Луус	579	0	222	339
Өлзийт	863	0	168	681
Өндөршил	487	0	241	238
Сайхан овоо	692	0	247	423
Хулд	742	0	247	484
Цагаандэлгэр	397	0	144	246
Эрдэнэдалай	1766	0	554	1191
<b>Дүн</b>	<b>14863</b>	<b>3732</b>	<b>3491</b>	<b>7333</b>

Нийт өрхийн тоо багаар-2018

Байр	Сум	Багийн нэр	хүн ам	Байр	Сум	Багийн нэр	хүн ам
1	СЦ	7-р баг, Нарлаг	1117	35	ХД	4-р баг, Бүлээн	175
2	СЦ	9-р баг, Мандал	892	36	ГС	2-р баг, Дэрсэнэ ус	174
3	СЦ	8-р баг, Айраг	677	37	ДН	1-р баг, Алаг-Өндөр	172
4	СЦ	5-р баг, Аривжих	587	38	ӨШ	1-р баг, Цог	170
5	СЦ	6-р баг, Боржигон	559	39	СО	4-р баг, Төгрөг	170
6	ЭД	7-р баг, Сумын төв	393	40	ЭД	3-р баг, Тэнгэлэг	168
7	СЦ	3-р баг, Далай	280	41	ДН	2-р баг, Саруул	166
8	ЭД	6-р баг, Сангийн далай	276	42	ХД	1-р баг, Шувуутай	165
9	СЦ	4-р баг, Үйзэн	264	43	ЛС	3-р баг, Зүлэгтий	163
10	ЭД	4-р баг, Рашаант	263	44	СО	3-р баг, Найз	162
11	СЦ	1-р баг, Наран	248	45	ӨЛ	6-р баг, Рашаант	161
12	СЦ	2-р баг, Тэвш	244	46	ӨЛ	2-р баг, Буянт-2	160
13	ЭД	5-р баг, Цагаан-Овоо	237	47	СО	2-р баг, Мааньт	157
14	ЭД	2-р баг, Өнгөт	229	48	АД	1-р баг, Тавин	155
15	ЛС	1-р баг, Суварга	214	49	ГУ	3-р баг, Хонгор	155
16	ХД	2-р баг, Олдох	212	50	АД	3-р баг, Өвөр-Урт	153
17	СО	1-р баг, Онги	203	51	ДХ	2-р баг, Таргат	152
18	ЛС	2-р баг, Наран	202	52	ДН	3-р баг, Долоод	152
19	ЭД	1-р баг, Цавчир	200	53	БЖ	2-р баг, Энгэр-Ус	151
20	ДЦ	2-р баг, Цахиурт	198	54	ДН	4-р баг, Бумбат	147
21	АД	5-р баг, Хашаат	197	55	ГС	3-р баг, Чулуут	143
22	ДХ	1-р баг, Толь	197	56	ӨЛ	4-р баг, Дэрт-1	135
23	ДЦ	1-р баг, Баянбулаг	196	57	ӨШ	3-р баг, Бөхт	134
24	ГУ	1-р баг, Ажирхай	195	58	ГС	5-р баг, Суугаант	126
25	ХД	3-р баг, Уул	190	59	ГС	1-р баг, Элгэн	121
26	ДЦ	3-р баг, Дэлгэр-Эмт	189	60	ГС	4-р баг, Гурвансайхан	120
27	ГУ	2-р баг, Морьт	187	61	ӨЛ	1-р баг, Буянт-1	116
28	ДХ	3-р баг, Ар шавагтай	187	62	ЦД	4-р баг, Замын-Улаан	114
29	АД	4-р баг, Сүм	184	63	ӨЛ	3-р баг, Тагт	113
30	ӨШ	2-р баг, Талын нар	183	64	БЖ	1-р баг, Шилийн гол	112
31	ДХ	4-р баг, Номгон	182	65	ЦД	1-р баг, Хараат	111
32	БЖ	3-р баг, Аргатай	180	66	ЦД	2-р баг, Дэлгэрэх зам	86
33	АД	2-р баг, Ар-Урт	178	67	ЦД	3-р баг, Жаргалант	86
34	ӨЛ	5-р баг, Дэрт-2	178			Бүгд	14863

Нийгмийн зарим үзүүлэлтүүд сумдаар

Сумд	Өнчин хүүхдүүд			18 хүртлэх насны хүүхэдтэй гэр бүлгүй хүн		Өрх толгойлсон гэр бүлгүй хүн		Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо			Ганц бие өндөр настан		
	2016	2017	2018	эцэг	эх	эцэг	эх	2016	2017	2018	2016	2017	2018
Дэлгэрцогт	18	20	25	3	45	10	61	61	75	79	60	57	53
Дэрэн	13	6	12	2	27	11	68	71	75	71	33	40	39
Говь-Угтаал	16	15	26	3	25	9	36	95	103	91	37	23	22
Цагаандэлгэр	22	20	8	4	14	17	47	17	17	24	30	67	33
Баянжаргалан	8	11	17	5	22	36	53	19	19	24	33	34	40
Өндөршил	17	12	22	3	20	22	64	47	45	41	36	33	41
Гурвансайхан	13	12	14	3	24	16	58	87	72	73	44	41	51
Өлзийт	25	18	19	11	68	55	80	68	74	80	98	54	80
Хулд	21	20	24	3	34	18	81	82	81	76	56	46	36
Луус	31	30	24	11	52	20	58	103	106	104	30	32	33
Дэлгэрхангай	25	21	38	7	62	14	93	78	122	127	46	48	42
Сайхан-Овоо	14	21	18	3	47	13	79	68	66	66	45	44	39
Эрдэнэдалай	62	65	67	15	97	25	213	219	231	190	162	142	176
Сайнцагаан	162	126	140	27	385	195	800	628	644	675	310	312	332
Адаацаг	22	25	35	3	43	27	122	104	100	105	49	56	53
Дүн	469	422	489	103	965	488	1913	1747	1830	1826	1069	1029	1070

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАЛ АЖ АХУЙ

### 1.МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО

## 1.1 Өрх, малчдын тоо, насны бүтэц

### Эдийн засгийн идэвхгүй хүн ам ба ажилгүй иргэдийн тоо



Эдийн засгийн идэвхгүй хүн амын 68.9 хувийг эмэгтэйчүүд, 31.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Суурьшлаар авч үзвэл 50.3 хувь буюу 3164 нь хөдөө, 49.7 хувь нь буюу 3125 нь аймгийн төвд байна. 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амыг насны бүтцээр авч үзвэл 30.0 хувь нь 15-19 насныхан, 10.0 хувь нь 20-29 насныхан, 4.0 хувь нь 30-39 насныхан, 5.0 хувь нь 40-49 насныхан, 18.0 хувь нь 50-59 насныхан, 33.3 хувь нь 60 болон түүнээс дээш насныхан бүрдүүлж байна.

### ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМ НАСНЫ БҮЛГЭЭР



Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 40.1 хувь нь тэтгэвэрт тэдгээрийн 68.6 хувийг эмэгтэйчүүд, 29.4 хувь нь суралцагчид байгаагийн 69.4 хувийг эмэгтэйчүүд, 10.9 хувь нь

хүүхдээ асарсны 95.5 хувь нь эмэгтэйчүүд, 10.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагийн 45.3 хувь нь эмэгтэйчүүд, 7.3 хувь нь өвчтэй байсаны 73.5 хувь нь эмэгтэйчүүд, 0.9 хувь нь гэрийн ажилтай, 0.4 хувь нь өндөр настан асарсан бүгд эмэгтэй, 0.4 хувь нь ажил хийхийг хүсээгүй гэсэн шалтгаантай иргэд 100 хувь эрэгтэйчүүд байна.


#### Эдийн засгийн идэвхгүй хүн ам шалтгаанаар

Шалтгаан	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Бүгд	6289	1957	4332
Гэрийн ажилтай	57	57	0
Суралцдаг	1847	566	1281
Тэтгэвэрт	2525	793	1732
Хөгжлийн бэрхшээлтэй	658	359	298
Ажил хийхийг хүсээгүй	28	28	0
Хүүхэд асарсан	685	31	654
Өвчтэй байсан	461	123	339
Өвчтөн, өндөр настан асарсан	28	0	28

#### 8. Ажил хайгч иргэн ба ажлын байрны зуучлал


2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ХХҮГазарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 487 болж өмнөх оны мөн үеэс 46.5 хувиар буурсан байна. Ажил хайгчдын 54.2 хувийг эмэгтэйчүүд 45.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

#### Бүртгэлтэй ажилгүйчүүд, жил бүрийн 12 сарын байдлаар



Ажил хайгч иргэдийн 24.0 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 9.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 34.0 хувь нь бүрэн дунд, 19.0 хувь нь суурь, 7.0 хувь нь бага, 3.0 хувь нь боловсролгүй иргэд, 0.6 хувь нь магистрын түвшиний боловсролтой иргэд байна.

Ажил хайгч иргэн, боловсролын түвшингээр, 2018 оны 12 сарын байдлаар



Аймгийн ХХҮГазрын мэдээгээр 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 635 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 126 хүнээр буюу 24.5 хувиар өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 43.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 9.6 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, 32.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 3.9 хувь нь барилга, 4.9 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, 9.3 хувь нь уул уурхай олборлолт, 11.2 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, 11.8 хувь нь боловсролын салбар, 3.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 2.8 хувь нь цахилгаан эрчим хүч, уур агааржуулалт, 3.9 хувь нь хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн чиглэлд зуучлагдсан бол үлдсэн хувь нь бусад салбарт зуучлагджээ.

АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2018 оны жилийн эцсийн байдлаар

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	61.0	20.0	9.6
Уул уурхай олборлох үйлдвэр	59.0	16.0	9.3
Боловсруулах аж үйлдвэр	6.0	2.0	0.9
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	18.0	3.0	2.8
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	3.0	1.0	0.5
Барилга	25.0	1.0	3.9
Бөөний ба жижиглэн худалдаа	24.0	15.0	3.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	2.0	1.0	0.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.0	11.0	2.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.0	3.0	0.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.0	1.0	0.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	71.0	24.0	11.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	31.0	16.0	4.9
Боловсрол	75.0	53.0	11.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25.0	14.0	3.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.0	5.0	1.4

Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	208.0	88.0	32.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
<b>Бүгд</b>	<b>635.0</b>	<b>274.0</b>	<b>100.0</b>

### 9. Албан бус секторт ажиллагчид


2018 оны ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо 4402 болж өмнөх оны мөн үеэс 49.2 хувиар өссөн бөгөөд тэдгээрийн 52.1 хувийг эмэгтэйчүүд, 47.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Харин давхар ажлаараа албан бус секторт ажиллагчдын тоо 717 байгаагийн 62.9 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

#### АЛБАН БУС СЕКТОРТ АЖИЛЛАГЧИД



Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчдын 29.8 хувийг 40-49 насныхан, 26.7 хувийг 50-59 насныхан, 21.2 хувийг 30-39 насныхан, 15.1 хувийг 60-69 насныхан эзэлж байгаа бол 7.1 хувийг 30-аас доош насныхан бүрдүүлж байна.

Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчид



Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчдын 32.0 хувь буюу 1407 хүн бөөний болон жижиглэн худалдааны салбар ажиллаж тэдгээрийн 53.6 хувийг эмэгтэйчүүд, 29.8 хувь буюу 1310 хүн боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллаж тэдгээрийн 59.5 хувийг эмэгтэйчүүд, 14.8 хувь буюу 653 хүн тээвэр агуулахын салбарт ажиллаж байгаагийн 8.7 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

Давхар ажлаараа албан бус секторт ажиллаж байгаа 717 иргэний 33.2 хувь нь хөдөө аж ахуйн чиглэлээр, 14.2 хувь худалдаа үйлчилгээний чиглэлээр 12.6 хувь нь үйлдвэрлэл гар

урлал барилгын чиглэлээр ажиллаж байгаа бол үлдсэн хувь нь бусад энгийн ажил мэргэжлийн чиглэлээр давхар хөдөлмөр эрхэлж байна.

Үндсэн ажлаараа албан бус секторт ажиллагчид

Ажиллагчид салбараар	Бүгд	эмэгтэй
Уул уурхай, олборлолт	179	28
Боловсруулах үйлдвэрлэл	1,310	780
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент б	31	0
Барилга	117	0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилг	1,407	754
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	653	57
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	342	249
Боловсрол	32	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	331	240
<b>Бүгд</b>	<b>4402</b>	<b>2109</b>

## 10.Хавсралт хүснэгтүүд

Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

Он	Нийт хүн амын тоо	Хөдөлмөр ийн насны хүн ам	Ажилла х хүч	Ажиллагч дын тоо	Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүртгэлтэй ажилгүйчүүд
2010 он	45.9	28.5	24.2	21.8	9224	848
2011 он	45.0	29.1	24.4	22.3	7455	638
2012 он	44.6	29.7	23.4	21.4	7514	828
2013он	44.4	29.7	21.6	20.2	9272	829
2014 он	44.2	29.5	22.1	20.9	7859	366
2015 он	44.9	29.8	21.2	20.1	7806	512
2016 он	45.5	30.1	22.2	21.1	8043	519
2017 он	46.4	30.5	23.7	22.6	6812	633
2018 он	46.8	30.8	24.5	23.3	6289	487

Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд,

Он	АХОТ	АХИЕК	ЭЗА	ХЭТ	Ат	ЭЗИБТ
2010 он	84.9	52.7	38.1	76.5	10.1	32.3
2011 он	83.8	54.2	30.6	76.6	8.8	25.6
2012 он	78.8	52.5	32.1	72.1	8.5	25.3
2013 он	72.7	48.6	42.9	68.0	6.3	31.2
2014 он	74.9	50.0	35.5	70.8	5.3	26.6
2015 он	71.1	47.2	36.8	67.4	5.5	26.2
2016 он	73.8	48.8	36.2	70.1	5.5	26.7
2017 он	77.7	51.1	28.7	74.1	4.4	22.3
2018 он	79.5	52.4	25.7	75.6	4.4	20.5

АХОТ-Ажиллах хүчний оролцооны түвшин  
 АХИЕК-Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент  
 ЭЗА-Эдийн засгийн ачаалал  
 ХЭТ-Хөдөлмөр эрхлэлтийн түвшин  
 АТ-Ажилгүйдлийн түвшин  
 ЭЗИБТ-Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин

Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсадын тоо

Он	Хөдөлмөрийн насны хүн ам	Ажиллах хүч	Ажиллагчдын тоо	ХН-ны 1000 хүнд ногдох	
				Ажиллах хүч	Ажиллагчдын тоо
2010 он	28.5	24.2	21.8	849.1	764.9
2011 он	29.1	24.4	22.3	838.5	766.3
2012 он	29.7	23.4	21.4	787.9	720.5
2013 он	29.7	21.6	20.2	727.3	680.1
2014 он	29.5	22.1	20.9	749.2	708.5
2015 он	29.8	21.2	20.1	711.4	674.5
2016 он	30.1	22.2	21.1	737.5	701.0
2017 он	30.5	23.7	22.6	777.0	741.0
2018 он	30.8	24.5	23.3	795.5	756.5

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА

### 1.Аж үйлдвэр



Дундговь аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 онд /оны үнээр/ нийт 9330.3 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 15.2 хувиар буюу 1232.5 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Дээрх өсөлтөнд уул уурхай олборлох аж үйлдвэр 19.6 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл 14.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, өсөлтийн хувийг Зураг.1-д харууллаа.

Зураг.1

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт,  
өсөлтийн хувь /2000-2018 он/




Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 4.5 хувиар өссөн байна.

Хүснэгт-1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/дэд салбараар, сая.төг/

	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2018/ 2017 %
<b>Дундговь-Нийт дүн</b>	<b>1118.4</b>	<b>1643.7</b>	<b>3066.5</b>	<b>7542.6</b>	<b>7233.1</b>	<b>8097.8</b>	<b>9330.3</b>	<b>115.2</b>
<b>Уул уурхайн олборлох аж үйлдвэр</b>	<b>81.9</b>	<b>170.5</b>	<b>797.31</b>	<b>4033.5</b>	<b>2959.9</b>	<b>3049.5</b>	<b>3648.3</b>	<b>119.6</b>
Нүүрс	78.3	136.1	218.6	393.7	500.6	379.9	427.3	112.5
Гөлтөнө	3.6	16	285.0	876	233.6	676.9	654.1	96.6
Жонш		18.4	293.7	2763.8	2225.7	1992.7	2566.9	128.8
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>688.7</b>	<b>922.1</b>	<b>801.06</b>	<b>1059.2</b>	<b>1152.9</b>	<b>1170.4</b>	<b>1225.8</b>	<b>104.7</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	618.7	706.2	636.4	653.6	836.7	879.6	944.0	107.3
Хүснэгт маягт үйлдвэрлэл	6.7	10.6	10.9	17.6	14.7	19.1	22.4	117.3
Боловсруулах бусад үйлдвэр	63.3	205.3	153.7	388	301.5	271.7	259.4	95.5
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</b>	<b>347.8</b>	<b>551.1</b>	<b>1468.1</b>	<b>2449.9</b>	<b>3120.3</b>	<b>3877.9</b>	<b>4456.2</b>	<b>114.9</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	257.4	447.7	1322.7	1947.3	2605.4	3200.4	3773.3	117.9
Ус ариутгал ус хангамж	68.2	103.4	145.4	502.6	514.9	677.5	682.9	100.8
Цахилгаан	22.2	0						

2018 оны байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 47.8 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, 39.1 хувийг уул уурхайн олборлох аж үйлдвэр, 13.1 хувийг боловсруулах аж үйлдвэр тус тус эзэлж байна. Үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 3 жилээр харууллаа. Зураг.2-т Аж үйлдвэрийн салбарын сүүлийн 3 жилийн бүтцийн өөрчлөлтийг дэд салбаруудаар харууллаа. 2018 оны салбарын бүтцийг өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 13 хувь болж 1 пунктаар буурч уул уурай олборлох салбар 39 хувь болж өмнөх онтой харьцуулбал 1 пунктаар өссөн байна.

## Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар



Зураг.2

### 1.1 Уул уурхай олборлох аж үйлдвэр

2019 оны 1 сарын 1-ны байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 98, хайгуулын тусгай зөвшөөрөл 12 сумын нутагт 115, нийт 213 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн нийт талбайн хэмжээ 783 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 10.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт-2. Ашиглалт хайгуулын зөвшөөрөл олгосон байдал /сумаар/

Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ Мян.га	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
	тоо	Талбай	тоо	Талбай			
		Мян.га		Мян.га			
1.Дэлгэрцогт					0	0	0.00
2.Дэрэн			3	6.3	3	6.3	1.73
3.Говь-Угтаал	11	5.1	3	3.9	14	9	3.31
4.Цагаандэлгэр	3	4.4	6	11	9	15.4	4.44
5.Баянжаргалан	29	22.2	11	24.2	40	46.4	14.50
6.Өндөршил	7	30.7	20	142	27	172.7	35.45
7.Гурвансайхан	13	49	13	62.7	26	111.7	20.44
8.Өлзийт	9	19	30	135.1	39	154.1	9.95
9.Хулд	4	4.3	20	126.3	24	130.6	21.44
10.Луус	2	0.2	10	46.7	12	46.9	14.82
11.Дэлгэрхангай	19	8.3	11	55.4	30	63.7	10.24
12.Сайхан-Овоо	1	1.4			1	1.4	0.34
13.Эрдэнэдалай	6	5.8	6	12.5	12	18.3	2.49
14.Сайнцагаан	6	5.3			6	5.3	1.58
15.Адаацаг	3	0.2	1	1	4	1.2	0.36
<b>Дүн/давхардсан тоогоор/</b>	<b>113</b>	<b>155.9</b>	<b>134</b>	<b>627.1</b>	<b>247</b>	<b>783.0</b>	10.5
<b>Давхардаагүй тоогоор</b>	<b>98</b>	<b>155.9</b>	<b>115</b>	<b>627.1</b>	<b>213</b>	<b>783.0</b>	10.5


Ашиглалтын 98 тусгай зөвшөөрлийн 30 нь жоншны, 24 нь нүүрсний /7 орд/, 17 нь гөлтгөний /3 орд/, 5 нь барилгын материалын, 7 нь төмөр-цайрын, 5 нь алтны, 2 нь шохойн чулууны, 1 нь өнгөт металлын, 1 нь бал чулууны, 1 нь литийний, 1 нь перлитын орд газар байна. Эдгээрийг 74 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай-40, хамтарсан хөрөнгө оруулалттай-17, гадаадын 100% хөрөнгө оруулалттай-17 байна.

Хайгуулын 115 тусгай зөвшөөрлийг 92 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай - 72, хамтарсан хөрөнгө оруулалттай- 8, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай – 12 аж ахуй нэгж байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 онд 3648.4 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 19.6 хувиар буюу 598.9 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.3/

Зураг.3


Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/сая төг/



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг өмнөх онтой харьцуулахад гөлтгөнө биет хэмжээгээр 32 хувиар, мөнгөн дүнгээр 3.4 хувиар буурсан бол нүүрс биет хэмжээгээр 2 хувиар буурч, мөнгөн дүнгээр 12.5 хувиар өссөн, жонш олборлолт биет хэмжээгээр 15.5 хувиар буурч, мөнгөн дүнгээр 28.8 хувиар өссөн байна. /Зураг.4, Хүснэгт.2/

Зураг.4

Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний өсөлт, бууралт /биет хэмжээгээр/



Хүснэгт-3. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018 /2017%
Хүрэн нүүрс	мян.тн	31.5	14.9	20.3	19	16	16.6	17.6	18.3	15.3	15	98.0
Жонш	мян.тн	14.9	17.3	30.8	16.4	13.5	30	32.6	26.8	11.6	9.8	84.5
Гөлтгөнө	мян.тн	1.5	3	0	0	0	0	12.7	7.3	38.1	25.9	68.0

2018 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн төсөвт 792.5 сая төгрөг, усны төлбөрөөс 57.9 сая.төгрөг, газрын төлбөрөөс 259.2 сая.төгрөгийн орлого орсон байна.

Хүснэгт-4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс төсөвт орсон төлбөр

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2018
Ашигт								
1	малтмалын нөөц ашигласны төлбөр	Сая.төг	814.3	876.9	784.1	4579.7	1465.4	792.5
2	Газрын төлбөр	Сая.төг	120	131	149	160.5	128.8	259.2
3	Усны төлбөр	Сая.төг	27.1	25.8	34.1	29.9	22.8	57.9

## 1.2 Боловсруулах аж үйлдвэр

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 1225.8 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 4.7 хувиар өссөн байна. Тус салбарын энэхүү өсөлтөнд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 7.3 хувиар, хүснэгт маягт үйлдвэрлэл 17.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэл 4.5 хувь буюу 12.3 сая.төгрөгөөр буурсан байна. / Зураг.5 /

Зураг.5



бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад хүснэгт маягт, талх, бялуу, архи, ундаа, хиам, тараг, ааруул, модон эдлэл үйлдвэрлэл өссөн бол нарийн боов, чихэр, цэвэр ус, гоймон, хэрчсэн гурил, вакум цонх хаалга, оёдол эсгүүр үйлдвэрлэл буурсан үзүүлэлттэй байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 10 жилээр өсөлт бууралтыг хүснэгт-4 д харууллаа.

Хүснэгт-5. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Хүснэгт маягт	м,х,д,х	167.4	156.8	149.7	116.6	210.7	197.1	250.5	210.1	272.9	320.1	1.17
Талх	тн	89.1	116.6	100.6	109.7	75.3	89.5	99.5	115.2	116.8	126.2	1.08
Нарийн боов	тн	89	174.5	107.6	105.4	102.4	93.1	98.7	112.8	115.4	111.5	0.97
Чихэр	тн	0	0	0	0	1.5	1.8	2.5	2.5	3.4	3.3	0.97
Бялуу	тн	0	0	0	0	0	0.9	2.3	3.7	1.1	2.1	1.91
Архи	мян.л	65.3	70	52.8	44.3	27	18.5	17.1	27.1	27.9	29.3	1.05
Ундаа	мян.л	9	6.4	7.5	3.4	4.3	1.6	1.4	2	1.7	8.6	5.06
Цэвэр ус	мян.л	6.1	3.2	5.7	2.1	5	5.7	8.4	7	15.4	24.1	1.56
Гоймон	тн	0	4.9	9.2	20.1	28.8	23.8	20.6	20.2	20.4	16.6	0.81
Хэрчсэн гурил	тн	0	0	0	0	5	9.4	8.8	9.1	9.6	4.2	0.44
Хиамны зүйл	тн	4.8	4.5	5.1	2.6	4	1.7	1.5	0.4	0.4	0.8	2.00
Тараг	мян.л	2.9	8	5.6	7.6	11.7	18.2	9.3	12.9	5.4	6	1.11
Хоормог	мян.л	2.1	1.2	2.5	2.7	1.1	0.6	0.2	0.7	0.7	0.5	0.71
Ааруул	тн	2.4	1.3	1.2	2.4	0.7	1.5	1.6	1.1	0.9	3.3	3.67
Вакум хаалга, цонх	м <sup>2</sup>	775	800	610	550	493	812	331	500	220	207	0.94
Блок	мян.ш	16	21.8	11.6	8.5	45.6	78.6	28.7	41.6	20	7.2	0.36
Оёдол эсгүүр	мян.төг	13170	11916	13059	24379	281756	194144	76204	92103	67765	54427	0.80
Модон эдлэл үйлдвэрлэл	мян.төг	38421	36205	47860	89201	120714	144975	214948	208273	102643	151560	1.48

Боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийг бүтцээр нь авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 75.2 хувь, хэвлэх үйлдвэр 1.6 хувь, боловсруулах үйлдвэрийн бусад салбарын үйлдвэрлэл 23.2 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад хүнсний үйлдвэрлэлийн эзлэх хувь 2.5 пунктээр, хүснэгт маягт үйлдвэрлэлийн эзлэх хувь 0.3 пунктээр өссөн үзүүлэлт бол харин боловсруулах үйлдвэрлэлийн бусдын эзлэх хувь 2.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн боловсруулах бусад салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс жижиг дунд үйлдвэрлэгчидийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онд тус аймагт зээл олгогдоогүй бөгөөд Жижиг дунд үйлдвэрийн бодлогын сангаас 2017 онд 1 ААН 1 төсөл, 2018 онд 2 ААН 2 төсөлд нийт 900 сая төгрөгийн зээл авсан байна. 2019 онд тус аймагт “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” –аас 1 тэрбум төгрөг хуваарьлагдаад байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой Сум хөгжүүлэх сан сүүлийн жилүүдэд тогтмол зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сан 2018 онд аймгийн хэмжээнд 63 төсөлд 713.2 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 48 ажлын байр хадгалагдаж, шинээр 79 ажлын байр нэмэгджээ. Зураг.6

Хүснэгт-6. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт, сумаар

Сум	2017 он				2018 он			
	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
Сайнцагаан	26	555,600	77	41	20	318,200	30	26

Луус	11	72,830	11	-	1	20,000	-	1
Хулд	12	91,000	12	-	8	56,500	8	-
Дэлгэрхангай	4	32,000	4	-	-	-	-	-
Сайхан-Овоо	11	38,500	6	11	-	-	-	-
Эрдэнэдалай	-	-	-	-	15	127,000	18	14
Адаацаг	22	84,500	11	11	6	65,500	6	-
Дэлгэрцогт	10	69,350	10	-	4	40,000	3	1
Дэрэн	-	-	-	-	-	-	-	-
Цагаандэлгэр	-	-	-	-	-	-	-	-
Говь-Угтаал	19	112,200	11	8	-	-	-	-
Баянжаргалан	5	41,500	5	-	-	-	-	-
Өндөршил	6	51,000	4	2	1	10,000	-	1
Гурвансайхан	2	33,000	2	-	4	39,000	6	1
Өлзийт	3	16,100	3	3	4	37,000	8	4
<b>Нийт</b>	<b>131</b>	<b>1,197,580</b>	<b>156</b>	<b>76</b>	<b>63</b>	<b>713,200</b>	<b>79</b>	<b>48</b>

Зураг.6

### Сум хөгжүүлэх сангийн зээл олголт



### 1.3 Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуй нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК, Тэвшийн говь ХХК болон Дундговь-Ус ОНӨУҮГ, Ариунболор ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн аймгийн нийт 14 сумаас 11 сум нь төвлөрсөн халаалтын системд холбогдоод байгаа бөгөөд үүнээс 6 суманд Ган-Илч компани дулаанаар ханган ажиллаж байна.


Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨҮГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨҮГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт, 2.1, 0.5 мв хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг

холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбар 2018 онд 4456.1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 14.9 хувиар буюу 578.2 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.7/

Зураг.7

### ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭЛ,УСАН ХАНГАМЖ /САЯ ТӨГ/



Мөнгөн дүнгээр авч үзвэл өмнөх онтой харьцуулахад дулаан үйлдвэрлэл 3773.3 сая төгрөгт хүрч, 17.9 хувь буюу 573 сая төгрөгөөр, усан хангамж ариутгал 682.9 сая төгрөгт хүрч 0.8 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын гол нэр төлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулвал сувагжуулалт 8.2 хувиар өссөн бол дулааны эрчим хүч 9.9 хувиар, түгээсэн цэвэр ус 0.3 тус тус буурсан байна.

Хүснэгт-7. Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж												
Дулааны эрчим хүч	мян.ккл	32.9	113.4	79.6	69.4	69.9	68.1	80.7	87.8	101.2	91.2	90.1
Түгээсэн цэвэр ус	мян.м <sup>3</sup>	50.7	40.9	70.9	58.7	80	76.4	100.3	89.1	122.3	121.9	99.7
Сувагжуулалт	мян.м <sup>3</sup>	28	26.8	41.2	37.7	44.8	49.8	66.9	67.7	78.3	84.7	108.2

## 2. Барилга



Дундговь аймгийн хэмжээнд 2018 онд 9515.0 сая төгрөгийн барилга угсралт их засварийн ажил хийгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 18.9 хувиар өссөн байна. Энэ онд 8971.8 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 543.5 сая төгрөгийн их засварын ажил хийжээ. /Зураг.8./

## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ /САЯ.ТӨГ/



2018 онд 700.0 сая төгрөгийн орон сууцны барилга, 3330.5 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 1350.0 сая төгрөгийн эмнэлгийн зориулалттай барилга, 85 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 1254.2 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 97.5 сая төгрөгийн эрчим хүчний зориулалттай барилга, 1509.9 сая төгрөгийн сургуулийн барилга, 629.0 сая төгрөгийн спорт биеийн тамирын зориулалттай барилга, 15.7 сая төгрөгийн далан суваг, шугамын ажил, 543.2 сая төгрөгийн орон сууцны бус их засварын ажил хийгдсэн байна.

Хүснэгт-8. Дундговь аймгийн барилга угсралт, их засварын ажлын бүтэц /сая.төг/

№	Барилгын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/2017 хувь
1	Орон сууцны барилга	4110.3	557.7	1950.0	1620.0	700.0	43.2
2	Орон сууцны барилга, гарааштай	3032.0	400.0	0.0		0.0	-
3	Худалдаа, үйлчилгээний	768.4	1436.7	4033.2	1462.3	3330.5	227.8
4	Эмнэлэг	376.0	861.0	179.3	300.0	1350.0	450.0
5	Цэцэрлэг	2122.8	258.5	0.0	-	-	-
6	Сургууль	2260.6	4818.0	130.0	-	1509.9	-
7	Соёлын	1140.0	2280.7	599.5	-	-	-
8	Спорт, биеийн тамир	187.7	1562.5	0.0	-	629.0	-
9	Конторын	1117.1	809.5	1460.5	80.3	85.0	105.9
10	Орон сууцны бус бусад барилга	731.1	1259.2	376.6	459.7	1254.2	272.8
11	Эрчим хүчний	4503.8	128.7	195.0	44.9	97.5	217.3
12	Хатуу хучилттай авто зам	0.0	1655.7	413.9	820.7	0.0	0.0
13	Сайжруулсан хөрсөн зам	0.0	1655.7	95.0	-	-	-
14	Далан, суваг, шугам	2081.1	453.6	0.0	164.3	15.7	9.5
15	Бусад (бусад зам, талбайн ажил)	1219.7	1886.7	220.3	268.3	-	-
16	Орон сууцны барилгын их засвар	116.4	0.0	1350.4	169.0	0.0	0.0
17	Орон сууцны бус барилгын их засвар	1734.3	1022.2	0.0	2562.1	543.2	21.2
18	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	397.2	0.0	94.5	52.0	0.0	0.0
	<b>Нийт</b>	<b>25898.6</b>	<b>21046.3</b>	<b>11098.3</b>	<b>8003.6</b>	<b>9515.0</b>	<b>118.9</b>

2018 онд манай аймагт өрнөсөн томоохон бүтээн байгуулалтаас дурдвал аймгийн төвд Захын урд төлд байрлах 16 айлын орон сууц, Бүрд зочид буудал зоогийн газар, Жаргалант худалдааны төвийн барилга зэрэг томоохон барилга баригдсан байна.

### 3.Тээвэр холбоо



**Тээвэр:** 2018 оны байдлаар зорчигч тээвэр 29.6 мянга болж өмнөх оноос 1 хувиар өсч, зорчигч эргэлт мөн 1 хувиар өсч 8140 мян.хүн.км болсон байна.


Хүснэгт-9. Зорчигч тээврийн мэдээ

Үзүүлэлт	хэмжих нэгж	2009	2014	2015	2016	2017	2018	2018/ 2017
Зорчигч эргэлт	мян.хүн.км	13743	12530.6	5961.7	12004.8	8057.5	8140	101.0
Зорчигчид Орлого	мян.хүн мян.төг	24.9 44449	30.2 53455.6	18.8 30757.2	43.6 32450.7	29.3 31601.5	29.6 34092.1	101.0 107.9

Зорчигч тээврийн орлого 34.1 сая төгрөг болж өмнөх оноос 7.9 хувиар буюу 2.5 мянган төгрөгөөр өссөн байна. /Зураг.9/

Зураг.9

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ОРЛОГО,МЯН.ТӨГ



**Холбоо:** Дундговь аймгийн хувьд Өлзийт, Дэлгэрхангай сумдаас бусад бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабель ашиглаж өндөр хурдаар интернэтэд холбогдож байна. Мөн 2018 онд тус аймгийн төвд Харилцаа холбооны салбарын тэргүүлэгч компаниудын нэг Юнител группын Юнивишн компани өрхийн интернэтийн холбоос, телевизийн суваг, суурин утас гурвыг нэгтгэсэн гурвалсан үйлчилгээ Юнивишн IPTV үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком бүх сумдад, скайтелын сүлжээ 11 сум /Цагаандэлгэр,Өлзийт сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/, жимобайл 14 суманд /Гурвансайханаас бусад/ сүлжээтэйгээс мобиком компани 10 суманд, юнител компани өөрийн сүлжээтэй Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумаас

бусад бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна.

Хүснэгт-10. Үүрэн телефоны сүлжээ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Дэлгэрцогт	<b>4жи</b>	<b>3жи,</b>	<b>4жи</b>	3 жи
Дэрэн	<b>4жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	2жи
Говь-Угтаал	<b>4жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	3жи
Цагаандэлгэр	<b>4жи</b>		<b>2жи</b>	2жи
Баянжаргалан	<b>4жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	2жи
Өндөршил	<b>3жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	2жи
Гурвансайхан	<b>4жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	-
Өлзийт	2жи		<b>4жи</b>	3жи
Хулд	2жи	<b>3жи,</b>	<b>4жи</b>	3жи
Луус	2жи	<b>3жи,</b>	<b>4жи</b>	3жи
Дэлгэрхангай	2жи	-	2жи	3жи
Сайхан-овоо	<b>4жи</b>	-	<b>4жи</b>	3 жи
Эрдэнэдалай	<b>4жи</b>	<b>3жи,</b>	<b>4жи</b>	3 жи
Сайнцагаан	<b>4жи</b>	<b>3жи, 2жи</b>	<b>4жи</b>	<b>3жи</b>
Адаацаг	<b>4жи</b>	<b>3жи,</b>	<b>4жи</b>	2 жи

Холбооны салбарын мэдээгээр 2018 онд тарифын орлого 431.3 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 0.6 хувиар өссөн байна. Интернет цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 1318 болж өмнөх онтой харьцуулахад 3.5 дахин буурсан бол суурин телефон цэгийн тоо 518 болж мөн 9.7 хувиар буурчээ.

Хүснэгт-11. Холбооны мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2013	2014	2015	2016	2017	2018	2018 /2017
Тарифын орлого	сая.төг	193	259.22	325.2	428.6	366.4	433.8	431.3	99.4
Үүнээс хүн амын	сая.төг	108.6	76.812	99.35	88.6	85.3	74	44.4	60.0
Суурин телефон цэг	тоо	796	695	686	647	640	518	468	90.3
Интернет цэгийн үйлчлүүлэгчдийн тоо	тоо	4830	10884	13573	9863	9329	4665	1318	28.3

#### 4.Бизнес регистрийн сан.

Статистикийн хэлтсийн бизнес регистрийн санд 2018 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 1057 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаа нь өнгөрсөн оноос 9.5 хувиар өссөн үзүүлэлт байна. Үүнээс 138 төсөвт байгууллага, 158 төрийн бус байгууллага, 21 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 648 ААНБ байна. Нийт аж ахуй нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар хүснэгт-11. д харууллаа.


Хүснэгт-12. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуй нэгж, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар

Сумын нэр	Үйл ажиллагаа явуулж байгаа		Үйл ажиллагаа эхлээгүй байгаа		Үйл ажиллагаа түр зогсоосон		Үйл ажиллагаа бүрэн зогсоосон		Бусад		Нийт	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дэлгэрцогт	20	20	3	3	0	0	0	1	0	0	23	24
Дэрэн	15	16	4	3	1	1	2	2	0	0	22	22
Говь-Угтаал	18	18	2	3	3	3	0	0	0	0	23	24
Цагаандэлгэр	14	15	5	4	0	0	0	1	0	0	19	20
Баянжаргалан	19	22	7	11	1	2	1	1	0	0	28	36
Өндөршил	25	23	3	4	12	14	1	1	0	0	41	42
Гурвансайхан	22	22	0	8	5	7	1	1	0	0	28	38
Өлзийт	21	20	5	8	5	5	1	2	0	0	32	35
Хулд	28	30	4	5	6	9	1	1	0	0	39	45
Луус	19	18	2	9	0	1	0	0	0	0	21	28
Дэлгэрхангай	24	26	4	5	3	4	4	2	0	0	35	37
Сайхан-Овоо	30	31	1	1	4	3	0	0	1	1	36	36
Эрдэнэдалай	37	37	3	6	8	8	1	1	0	0	49	52
Сайнцагаан	324	338	100	112	96	110	14	22	1	1	535	583
Адаацаг	23	27	4	1	5	6	2	1	0	0	34	35
Нийт	639	663	147	183	149	173	28	36	2	2	965	1057

Нийт ААН-ийн 62.7 хувь нь буюу 663 ААН, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-н тоог сүүлийн жилүүдээр графикт харууллаа. /Зураг.10/

Зураг.10

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ААН, ҮҮНЭЭС ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-Н ТОО



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагыг салбараар авч үзвэл 33 хувь буюу 220 нь бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Дэлгэрэнгүйг Зураг.11-т харууллаа.

Зураг.11

### Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага /эдийн засгийн салбараар, 2018 он/




### 5. Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/

ДНБ нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод гадаадын аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог бөгөөд Аймгийн ДНБ-ийг Монгол улсын Үндэсний Статистикийн хорооноос харьяатын зарчмыг баримтлан тооцож байна. Аймаг бүсийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон орлогын аргыг хослуулан тооцдог.

2018 оны аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 319.5 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 23.8 хувиар буюу 61.3 тэрбум төгрөгөөр өссөн байна./Зураг.12/

Зураг.12


### Дотоодын нийт бүтээгдэхүүн/оны үнээр, тэрбум.төг/



Дундговь аймгийн ДНБ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр төвийн бүсийн ДНБ-ий 11 хувийг эзлэж байна./Зураг.13/

Зураг.13

## Төвийн бүсийн ДНБ бүтэц-2018



■ Дорноговь	■ Дундговь	■ Өмнөговь	■ Сэлэнгэ
■ Төв	■ Дархан-Уул	■ Говьсүмбэр	

Аймгийн ДНБ-ийг бусад төвийн бүсийн аймгуудтай харьцуулан сүүлийн жилүүдээр хүснэгтэд харууллаа.

Хүснэгт-13. Төвийн бүсийн аймгуудын ДНБ, сая.төг

Төвийн бүсийн аймгууд	2013	2014	2015	2016	2017	2018*	2018/ 2017
Дорноговь	273119	308754.4	261319.1	272288.4	296014.8	349617.2	118.1
<b>Дундговь</b>	<b>179401</b>	<b>213115</b>	<b>237565.8</b>	<b>226072.5</b>	<b>258177</b>	<b>319543.6</b>	<b>123.8</b>
Өмнөговь	454724.4	335829.8	281273.5	404035.8	714470.2	597384.9	83.61
Сэлэнгэ	492578.3	586241.7	574519.5	555423	598216.1	680615.3	113.8
Төв	374514.9	474494.1	542576.3	510608.8	510446.5	594206.5	116.4
Дархан-Уул	305144	362087.7	367262.7	387260.4	409544.4	435751.1	106.4
Говьсүмбэр	57641.5	72860.8	83724.4	83354.9	83959.4	91702.8	109.2

2018 оны ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 61 хувь, тэр дундаа мал аж ахуйн салбар 60.8 хувийг аж үйлдвэрийн салбар 15 хувь, барилгын салбар 0.1 хувь үйлчилгээний салбар 24 хувийг тус тус эзэлж байна. ДНБ-ий бүтцийг эдийн засгийн салбараар дэлгэрэнгүй хүснэгт 14-т харууллаа.

Хүснэгт-14. Дундговь аймгийн ДНБ-ний бүтэц


Салбар	2013	2014	2015	2016	2017	2018*	Эзлэх %
ДНБ, зах зээлийн үнээр /сая.төг/	179401	213115	237565.8	226072.5	258177	319543.6	
<b>Хөдөө аж ахуй</b>	<b>108700.8</b>	<b>130102.3</b>	<b>142675.6</b>	<b>124658.5</b>	<b>146308.6</b>	<b>194903.7</b>	<b>61.0</b>
Газар тариалан	151	236	200.1	378.8	431.9	432.6	0.1
Мал аж ахуй	108549.7	129866.3	142475.5	124253.5	145876.7	194416.4	60.8
ХАА-н бусад	0	0	0	26.2	0	54.8	0.0
<b>Үйлдвэрлэл</b>	<b>21319.2</b>	<b>22001.2</b>	<b>28305.9</b>	<b>31922.3</b>	<b>37832.3</b>	<b>47813.1</b>	<b>15.0</b>
Уул уурхай, олборлох	867.5	1329.4	3296.1	2472.1	2018.5	2669.7	0.8
Боловсруулах	18251	18133.2	22584.8	26195.3	32818.9	42119.7	13.2

Цахилгаан, хий, уур хангамж; усан хангамж	1726.9	2055	2146.4	2992.6	2766.7	2730.7	0.9
<b>Барилга</b>	<b>473.7</b>	<b>483.6</b>	<b>278.7</b>	<b>262.4</b>	<b>228.2</b>	<b>292.9</b>	<b>0.1</b>
<b>Үйлчилгээ</b>	<b>49381.1</b>	<b>61011.6</b>	<b>66584.3</b>	<b>69491.7</b>	<b>74036.1</b>	<b>76826.8</b>	<b>24.0</b>
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	8051.5	8337.5	7633.5	7338.3	7911.6	9207.6	2.9
Тээвэр, мэдээлэл, холбоо	4466	5038.6	4925.7	4241	5367	5371.6	1.7
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	12137.5	14433.9	18053.1	19002.4	21008.1	20726.5	6.5
Бусад үйлчилгээ	24726.1	33201.6	35972	38910	39749.4	41521.1	13.0

Аймгийн 1 хүнд ногдох ДНБ 2018 онд 6856.9 мянган төгрөгт хүрсэн байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 22 хувиар өссөн үзүүлэлт юм. Зурагт аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ийг сүүлийн 10 жилээр харууллаа. /Зураг.14/

Зураг.14


АЙМГИЙН НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ  
/МЯН.ТӨГ/



Нэг хүнд ноогдох ДНБ 2018 онд улсын дундаж 10159.3 мянган төгрөг, Улаанбаатар хот 14933.9 мянган төгрөг байгаа бол Орхон аймгийн нэг хүнд ноогдох ДНБ хамгийн өндөр буюу 17912.1 мянган төгрөг байна. Манай аймгийн хувьд 6856.9 мянган төгрөгт хүрсэн нь 21 аймгаас нэг хүнд ноогдох ДНБ-ээрээ 5 дугаарт эрэмбэлэгдсэн үзүүлэлт юм. Зурагт нэг хүнд ноогдох ДНБ-ийг Улсын дундаж, Улаанбаатар хот болон 21 аймгуудаар зэрэгцүүлэн харууллаа. /Зураг.15/

Зураг.15

Нэг хүнд ногдох ДНБ-2018 /оны үнээр, мян.төг/



2018\*- 2018 оны ДНБ-ийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон болно.